



МОНГОЛ УЛСАД ХУЯГТ ТАНКИЙН ЦЭРЭГ ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ ТҮҮХТ 78 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ХҮРГЭЭ!

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм, Монголын танкчин генерал, офицер, ахлагч, сонсогч, ажилтан алба хаагчид аа.

Төрөлх Монгол орныхоо уудам сайхан нутаг усандаа аж төрөн суугаа ахмад танкчин дайчид Та бүхэндээ, Монгол Улсад хуягт танкийн цэрэг үүсэн байгуулагдсаны 78 жилийн ойн баярын мэндчилгээг Монголын танкчидын холбооны нэрийн өмнөөс дэвшүүлж, эргүүл энх, аз хийморь, амжилт ялалт бүхнийг хүсэн ерөөж байна.

1943 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр Монгол Ардын хувьсгалт цэрэгт "Танкийн тусгай рот" анх байгуулагдсан нь манай хуягт танкийн цэргийн 80 шахам жилийн түүхэн замнал, дайчин цэрэг эрсийн бахархал, омогшлын эхлэл байлаа.

Монголын танкчид, Дэлхийн II дайны төгсгөлөөр, "Чөлөөлөх дайн"-ы ялалтад оруулсан бодит хувь нэмрийг зөвхөн Монгол, Зөвлөлт, Хятадын ард түмэн төдийгүй, Ази тив даяар мэдэж байдгийг түүх гэрчилнэ. Тэр үед Монголын танкчид, байгаль цаг уур, газар орны хүнд бэрх нөхцлийг даван туулж, Халх гол, Хянганы их нурууг гаталж, фронтын шугам дээр дайсантай нүүр тулан байлдаж явсан баатарлаг түүхтэй. Өнөөдөр, дэлхий

даяар тархсан цар тахалтай тэмцэж байгаа энэ цаг үед манай танкчид үүргээ нэр төртэй биелүүлсээр байгааг хэлэхэд таатай байна.

XXI зуунд Монголын танкчид, зэвсэг нэгт бусад нөхдийн хамтаар "Олон улсын энхийг дэмжих ажиллагаа"-нд НҮБ-ын мандат дор хариуцлагатай, идэвх зүтгэлтэй оролцож, эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөж яваа төдийгүй мэргэжлийн цэргийн олон улсын хэмжээний "Танкийн биатлон" тэмцээнд амжилттай оролцож, өндөр чансаа, мэргэжлийн ур чадвараа гайхуулж Монголын хуягт танкийн цэргийг хөгжүүлж бэхжүүлэх үйлст хувь нэмрээ оруулж байна. Танкчин та бид, ахмад, дунд үе болон залуу халаа болсон сонсогч, сурагчдын амин холбоо, мэргэжлийн залгамж чанар, дайчин уламжлалаа хадгалж арвижуулахын төлөө ажиллаж байна, цаашид ч чадах бүхнээ эх орондоо зориулах болно.

Монголын танкчидын түүхэн замнал, мятаршгүй зүтгэл, мэргэжлийн өндөр чадвар улам батжиж, байлдааны болон техникийн бэлтгэл ямагт бэлэн байж, хуягт танкийн цэргийн сүр сүлд мандан бадраг.

"МОНГОЛЫН ТАНКЧИДЫН ХОЛБОО"-НЫ ТЭРГҮҮН, ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР, ЧӨЛӨӨНД БАЙГАА ХОШУУЧ ГЕНЕРАЛ Б.ЭРДЭНЭБАТ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 13	☁️ 0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	☁️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.849.0	2.851.0
EUR 🇪🇺	3.375.0	3.388.0
CNY 🇨🇳	441.5	442.3
RUB 🇷🇺	38.50	39.60
JPY 🇯🇵	25.73	26.17
KRW 🇰🇷	2.42	2.51

ЗУРХАЙ

2021.09.09 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 3/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН НАЙМАН ЦАГААН ЦАГААЧИН БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Эд мал баялаг төгөлдөр болно

Наран ургах, шингэх:

06.21-19.18

Барилдлага:

Хотол чуулган

Шүтэн барилдлага:

Сансар

Суудал:

Ус

Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, эрдэнийг гадагш өгөх, мал худалдан авах, мал түгээх, сахил санваар авах, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Хануур, төвөнүүр хийлгэх, балеадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод зүүн хойш мөрөө гаргавал зохистой.

ДУРСАМЖ

ХУЯГТ ТАНКИЙН АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР, ОФИЦЕР БЭЛТГЭХ АНХНЫ ШАНГ ТАТАЖ БАЙЛАА



Хуягт танкийн тэнхимийн даргаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Н.Довчинбавуу сургалтын материаллаг баазыг өргөтгөх, дадлагуулахад голлон анхаарч, сургалтын баримт бичгүүд, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгохыг зорьж байлаа. Тухайлбал, 1987 онд сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хичээлийн тоог 36 хүртэл багасган шалгалт шүүлгийн тоог 10-аас хэтрүүлэхгүй байхаар төлөвлөж, 5892 цагийн хичээлийг үзэж, Хуягт танкийн ашиглалтын инженер, дээд боловсролтой офицер бэлтгэхээр төлөвлөгөө боловсруулж, онол дадлагын цагийн харьцааг 1:1 байхаар өөрчилж, сургалтад мөрдсөн байна. 1990 онд

тухайн үеийн нийгмийн харилцаанд өөрчлөлт гарсантай холбогдуулан цэргийн мэргэжил нь хөрвөх чадвартай орчин үеийн шаардлагад нийцэж байхаар тухайн үеийн ШУБЯ-ны шаардлагад нийцүүлэн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан. Энэ төлөвлөгөөнд коммунист нам, МАХН-ын түүх, Улс төр, эдийн засгийн ухаан зэрэг хичээлийг хасаж, Монголын түүх, Монгол бичиг зэрэг хичээлийг нэмж үзэхээр төлөвлөсөн байдаг. 1994 онд ахин сургалтын төлөвлөгөөг шинэчлэн шаталсан сургалтын зарчимд шилжүүлж, 2-3 жилд дунд мэргэжлийн офицер, 4-5 жилд дээд мэргэжилтэн бэлтгэн гаргахаар төлөвлөсөн ба улмаар олон улсын жишигт нийцүүлж, үзэх цагийн кредитэд шилжүүлж сонсогч сурагчдад биеэ дайчлан суралцах бололцоог олгосон юм.

Тэрээр 1986-1996 оны хооронд сургалтын материаллаг баазыг бэхжүүлж, өргөтгөхөд мөн анхаарч Таван толгойн сургалтын төвд танк дромыг шинээр байгуулан хуягт танкийн жолоодлогын дасгалын элементүүдийг байгуулан дадлагын танхим, тренажёруудыг байрлуулж, буудлагын талбайг Очир толгойн орчимд шинээр байгуулж, байлдааны сумаар буудах нөхцлийг бий болгосон юм. 1987 онд танкийн 100мм-н их бууны Т-10д, 2ТС, циклон иж бүрэн танхим нэгийг, 1989 онд танк ЯЦБМ-ны бие ангийн хоёр танхимыг шинээр авч сургалтад ашигласан. Мөн 1990 онд шүүлтүүр, касет угаагч стэнд, консервац хийх агрегат АКД шинээр нэмж авчээ.

1994 оноос шаталсан сургалтад шилжих зарчмын эхлэл тавигдсантай холбогдуулан, сургалтын материаллаг баазыг өргөтгөн ЯЦБМ-ны ажиллагаат стэнд 1 ком, БТС-4 чирэгч, Т-55 танк, БТР-60, ПБ хуягт, БТУ, ТРМ-А танк засварын машиныг тус тус авч, дадлага үйлчилгээний байрыг шинээр тоноглон ашиглалтад оруулсан байна. Сургалтын материаллаг баазыг ийнхүү сайжруулан өргөтгөхийн зэрэгцээ сурах бичиг, гарын авлага бэлтгэхэд анхааран багш дэд хурандаа Б.Хулжаадай "Дизель хөдөлгүүр-1, 2-р дэвтэр", Х.Даваа "Танкийн жолоодлого", багш дэд хурандаа Ж.Таяа "ЯЦБМ-ны ашиглалт", "БТР-60 лб-ын ашиглалт", багш хурандаа Л.Уртнасан, Ж.Таяа нар "ХТТ-ийн хадгалалт"-ын гарын авлага, хурандаа Л.Уртнасан "Буудлагын хичээлийг зохион байгуулах" гарын авлага, хурандаа Н.Довчинбавуу, дэд хурандаа Ч.Баттөмөр нарын "ХТТ-ийн татан гаргалт" зэрэг гарын авлагуудыг сургуулийн хэвлэлээр хэвлүүлэн ашигласны зэрэгцээ ХТТ-ийн үйлчилгээний технологийн картуудыг боловсруулан сургалтад ашиглаж байсны үр дүнд төгсөн гарсан сонсогчид цэргийн ангид очоод чадварлаг мэргэжилтэн болдог байлаа. Дадлагын байрыг шинээр хийсний зэрэгцээ дадлагуулагч багшийн орон тоог бий болгон туршлагатай ахлагч нарыг ажиллуулсан нь ихээхэн ач холбогдолтой болсон юм.

Бэлтгэл хурандаа Н.ДОВЧИНБАВУУ

ТАНКЧИДЫН АЛДАР

Техникийн цэргийн сайхан сүр Танкийн цэргийн жагсаалд байдаг Түмэн цэрэг дагуулсан танкаар Түрэмгий дайсныг дарсан юм Хүчит моторын хүнгэнэсэн дуу Хуягт танкийн хөдөлгүүр байдаг Хуягт танкийн гинж тачигнасан Хүчирхэг армийн дуулал юм Битүү хуягаар хуягласан бартаа

туулагч машин байна Байлдах зэвсгээр тоноглогсон буудлагын цэргийн бахархал Хатан зоригт танкчидын гал бадарсан жагсаал байна Ган хуягт танкийн дуу газар нүргэм доргиож байна.

Техникийн цэргийн сайхан сүр Танкийн цэргийн жагсаалд байлаа Түмэн цэрэг дагуулсан танкаар Түрэмгий дайсныг дарсан юм Битүү хуягаар хуягласан бартаа туулагч машин байна Байлдах зэвсгээр тоноглогсон буудлагын цэргийн бахархал Хатан зоригт танкчидын гал бадарсан жагсаал байна Ган хуягт танкийн дуу газар нүргэм доргиож байна



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 243,820 +3963	ЭДГЭРСЭН 240,032 +3560	НАС БАРСАН 982 +6
НИЙТ БАТЛАГДСАН 4790 +83	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 187 +41	ЭДГЭРСЭН 4531 +38

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 223,368,662
Эдгэрсэн Нийт: 199,873,841
Нас барсан Нийт: 4,608,597

ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД АА!



ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД АА! ЭМЧНД ЯАРАЛТАЙ ХАНДААРЫ!

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХЭД ТАНКИЧДЫН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР АСАР ИХ



Шинэхэн сонсогч миний бие 1979 онд ЦЕДС-д элсэн суралцаж, олон авын хөвгүүдтэй бүрэн дуунаар нэгэн хүн шиг сэрж, мөр зэрэгцэн жагсаж, тохой нийлүүлэн сууж сурч хөдөлмөрлөсөн дөрвөн жилийн хугацаанд Цэргийн Ерөнхий Дээд сургуулийн Танкийн тэнхимийн эрдэмтэн багш, дарга захирагч нар маань надад цэргийн хүний дүр төрх суулган зориг тэвчээр, тэсвэр хатуужил, хүнлэг чанар, чанд сахилгатай болгон хүмүүжүүлж, амьдрах ухаанд сурган бие бялдрын хувьд төлөвшүүлсэн нь миний цаашдын амьдралын суурь болсон юм. Бидний 40 гаруй хүүхэд газар, газраас цугларан ЦЕДС-ийн хашаанд цэрэг хувцсаа өмсөөд Танкийн курсийнхэн хэмээн нэрлэгдэж, Улиастай дахь сургалтын төв рүү курсийн орлогч түрүүч Энх-Амгалангар удирдуулан зорьж байсан маань сахсан мэт санагдаж байна.

Бид сар гаруй хугацаанд цэргийн анхан шатны бэлтгэл хийж, цэргийн тангараг өргөөд Улаанхуаран дахь сургуулийн үндсэн байрлалдаа ирж, хоёр курсэд хуваагдан хичээл сургуульдаа орсон билээ. Ийнхүү ЦЕДС-ийн анхны рот үүсэн байгуулагдахад ротын захирагчаар ахлах дэслэгч /хурандаа/ Д.Буянтогтох, Улстөрийн орлогчоор дэслэгч /хошууч/ С.Батхүү, Курсийн захирагчаар дэслэгч Р.Мягмар /ахлах курсийн/, дэслэгч /дэд хурандаа/ Т.Содном, дэслэгч /хурандаа/ С.Ноов нар ажиллаж байв. Бид бүхний эрхэмлэн хүндэтгэж явдаг танкист хэмээх энэхүү эрхэм сайхан мэргэжлийг эзэмшүүлэхээр Танкийн кафедрын дарга дэд хурандаа Г.Цэнд-Аюуш, орлогч дарга хошууч Пүрэвдорж, багш дэд хурандаа Ц.Гончиг, Ж.Таяа, С.Сэдэд, Х.Даваа Ч.Баттөмөр, А.Долгорсүрэн, Б.Доржпалам нар ажиллаж байлаа.

Кафедрын дарга, багш нар маань бидэнд мэргэжил эзэмшүүлэхэд ихээхэн анхаарч хичээл сургуулийн үзүүлэн таниулах материал, хэрэглэл дутмаг ч гэсэн хичээл сургуулийг анги байгууллага, хөдөө хээр газар оронд заадаг нь ихээхэн сонирхолтой байсан билээ. Тухайлбал, Б.Доржпалам багш танкийн галын бэлтгэлийн хичээлийг заахдаа Улиастайн сургалтын төвийн орчим танкаа жалганд байрлуулан ПКТ пулемёт тусгалд оруулах хичээлийг биечлэн зааж,

хүн нэг бүрээр 100 м-т алхдаг метрээр хэмжүүлэн тусгалын бай тавиулж, буудлагын дасгал хийлгэж сургасан нь хэзээ ч мартагдахааргүйгээр санаанд минь тодхон үлджээ. Ц.Гончиг багш тактикийн хичээл заадаг, бид 3:3-аараа нэг экипаж болж, Япон толгой, Улиастайн голоор өгсөж уруудан мөн ч их гүйсэн дээ. Энэ нь тухайн үедээ зарим нөхдөд маань төвөгтэй байсан ч офицер болох бидэнд онолын болон дадлага, туршлага бие бялдрын давхар хүмүүжил олгож байсан юм.

Багш нар маань ОХУ-аас ирүүлсэн танкийн техникийн үзүүлэн таниулах материалыг ашиглан цахилгаан тоноглол, зохион байгуулалт, жолооны болон галын бэлтгэл, эд ангийн танхимуудыг тохижуулсан, мөн Д.Мягмар багш маань Улиастай дахь танкром байгуулсан зэрэг нэр их хөдөлмөрийг өрнүүлж байлаа. ЦЕДС-д суралцаж байхад эрдэмтэн багш нарын маань өгсөн мэдлэг дадлага, цэргийн байранд /казармд/ амьдарч сурч боловсорсон 4 жилийн хугацаа, салааны захирагчаас эхлэн шат шатны албан тушаалуудад томилогдож шантралгүй ажиллах тэвчээр хатуужлыг надад олгосон амьдралын туршид мартахын аргагүй дурсамжтай үе юм.

Намайг тангчин болгож, амьдралын замыг минь зааж өгсөн хүн бол манай кафедрын анхны багш нарын нэг дэд хурандаа А.Долгорсүрэн гуай билээ. 1979 онд 10 дугаар ангиа төгсөөд их дээд сургуулийн хуваарь авахаар сургуулийн захирлын өрөөнд шалгалтын комисс дээр орж, цэргийн сургуульд суралцах хүсэлтэйгээ хэлтэл ягаан костюмтай буурал толгойтой хүн надад танкийн талаар маш их зүйлийг ярьж тайлбарлаж өгч билээ. Би өмнө нь танк гэдгийг сонсож байснаас бодитоор нь хараа ч үгүй байсан ч сэтгэл татагдаад шууд л танкийн ашиглалтын инженерийн мэргэжлийг сонгон суралцахаар боллоо.

1979 оны 9 дүгээр сард хичээл эхэлтэл надад танкийн тухай нүдэнд харагдал ярьж тайлбарлаад байсан хүн маань бидний багш дэд хурандаа А.Долгорсүрэн агсан байж билээ. Зэвсэгт хүчнийг бэхжүүлэхэд танкийн кафедрын оруулсан хувь нэмэр асар их гэдгийг тэмдэглэн хэлэхийг хүсэж байна. ЦЕДС-ийн Танкийн кафедрт суралцаж, цэргийн хэргийн мэдлэг, боловсрол эзэмшиж, дэслэгчээс бригадын генерал хүртэлх цолыг хүртэж, төрийн дээд шагнал Цэргийн гавьяаны улаан тугийн одон болон ойн медалиуд, БХЯ-ны Хүндэт тэмдэг-ээр шагнуулан, Зэвсэгт хүчинд өдий зэрэгтэй ажиллаж байгаа минь эрдэмтэн багш, дарга захирагч нарын маань хайр халамж, тэдний сурган хүмүүжүүлэх ур ухаан, цэргийн даргын хүнлэг сайхан сэтгэлээр намайг амьдралын замд хөтлөн оруулсан сургууль, хуягт танкийн тэнхимийн маань ач тус гэж бодож хүндэтгэж явдаг билээ. Төрийн хошой одонтой арванзал улаан тугийн дор тангчин хэмээх эрхэм сайхан мэргэжил эзэмшихээр суралцсан 4 жил бол миний амьдралын хэзээ ч мартагдашгүй сайхан үе байлаа. Алдар гавьяат дайчин замналтай Хуягт танкийн цэрэг үүсэн байгуулагдсаны түүхт 78 жилийн ойг тохиолдуулан үе үеийн танкистууддаа амжилт бүтээл, аз жаргалыг хүсэн ерөөе.

Тангчидын яруу алдар бадартугай.
Бригадын генерал Н.НАРАН-ОЧИР

УВС АЙМГААС ҮХЭР ТЭРГЭЭР СУРГУУЛЬДАА ИРСЭН СОНСОГЧ

Хуягт танкийн тэнхим байгуулагдсаны 40 жилийн ой 2018 онд тохиож байлаа. Тус ойн хүрээнд ахмад багш нарын дурсамж номыг эмхэтгэн гаргах үүрэг надад оногдлоо. Би ой тэмдэглэх комиссын санхүүгийн хяналтын дарга Ж.Батнасангаас дурсамжаа бичиж өгөхийг хүсэв. Гэтэл дарга "Чи намайг мэдэхгүй биш дээ, үүнийг харж байгаад биччих гээд дөрвөн жилийн өмнө Цэргийн гавьяаны одонд тодорхойлж байсан БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан бичиг, тодорхойлолтыг өглөө. Тэгэхээр нь би "Тэгвэл таныг Увс аймгаас үхэр тэргээр сургуульдаа ирсэн сонсогч гээд бичих юм уу" гэж асуув. Дарга над руу зальжин харж, инээснээ "Өөрөө мэдээд бич" гэлээ. Уг нь тийм явдал болоогүй юм билээ. Курсын анд, нутаг нэгт Ц.Ядмаагийн гаргасан онигоо гэдэг. Дарга маань 4 дүгээр курсынхээ өвлийн амралтаар нутагтаа очиж амарчээ. Сонсогч өвлийн амралтаараа 14 хонох байтал дарга 60 хоног амраад иржээ. Гэтэл амралтаас хоцорсон гээд сургуулиас хасах асуудал яригдаж, төгсөх курсын сонсогч байж хариуцлага алдсан гэмтэн болж, сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар орох болжээ. Гэтэл нутгийн анд Ц.Ядмаа хүрч ирээд, "Миний найз зөвлөл дээр ороод амралт дуусаад буцах болсон чинь цас их ороод унаа олдохгүй байсаар байгаад хоцорсон гэж хэл. Унаа олдохгүй болохоор нь гэрээсээ үхэр тэргээр сум ороод, тэндээсээ морь олж унаад аймаг ороод нэг машинд суугаад ирсэн гэж хэл" гээд баахан зааварчилгаа өгсөн байна. Энэ яриа болсон эсэхийг мэдэхгүй ч бидний дунд энэ яриа "Гэрээсээ үхэр тэргээр гарч сургуульдаа ирсэн" хүний тухай олон явган яриа байсан юм.

Миний дарга Ж.Батнасан нь 1959 онд Увс аймгийн Хяргас суманд төрсөн. 1978 онд Улаангом хотын 10 жилийн сургууль, 1982 онд ЦЕДС-ийг хуягт танкийн ашиглалтын инженер мэргэжлээр төгссөн ба 1995 онд Боловсролын хүрээлэнд багш, 2003 онд БХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академийн стратегийн дамжааг тус тус дүүргэсэн. Хуягт танкийн ашиглалтын инженер мэргэжилтэй, техникийн ухааны магистр цолтой. 1982 оноос ЦИС-д курс, салбарын захирагч, Сургалтын хэлтсийн цэргийн алба эрхэлсэн ахлах офицер, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид захирагчийн орлогч, штабын дарга, БХИС-ийн танкийн тэнхимд багш, Зэвсэгт хүчний 311 дүгээр



ангид захирагчийн орлогч, ар талын дарга, Зэвсэгт хүчний 072-р ангийн захирагч, БХЯ, ЗХЖШ-ын ҮААХ-ийн орлогч, Хэлтсийн дарга, "Монгол цэрэг жуулчин" ТӨҮГ-ын дарга, орлогч, "Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв" ТӨҮГ-ын захирлаар тус тус томилогдон ажиллаж байна. Зэвсэгт хүчинд 30 гаруй жил алба хаахдаа БХИС-ийн курсийн захирагчаас ангийн захирагч, хэлтсийн дарга хүртэлх албан тушаалд дэвшин ажилласны зэрэгцээ БХИС-д багшилж, Зэвсэгт хүчинд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх үйлсэд өөрийн мэдлэг боловсролоо зориулан 200 гаруй офицер, 180 гаруй танк, ЯЦБМ-ны механик жолооч бэлтгэн гаргасны зэрэгцээ "Жагсаалын бэлтгэл хичээлийн заах арга зүйн зөвлөмж", "Танк, ЯЦБМ-ны буудлага, жолоодлогын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм" зэрэг гарын авлага, "Хуягт танкийн техникийн ашиглалтын явцад шатах тослох материал хэмнэх боломж" сэдэвт эрдэм шинжилгээний ажлын илтгэл зэргийг боловсруулан гаргасан байна. Даргын танчин гэхээсээ илүү ар тал, аж ахуй, санхүүгийн хүн гэвэл тохирно. Ясны аж ахуйн хүн гэж хэлбэл бүгд хүлээн зөвшөөрөх байж.

Хурандаа Т.СОРОНЗОНБОЛД

ХУЯГТ ТАНКИЙН МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭЖ ИРСЭН ТҮҮХЭН ТОВЧООН



Одоогоос 40 жилийн өмнө, ЦНДС-ийн бүтцэд "Хуягт танкын тэнхим" байгуулсан үйл явдал нь ҮБХИС-ийн хөгжил дэвшлийн түүхэн замнал, түүний он дарааллын хуудсыг баяжуулсан олон үйл явдлын нэгэнд зүй ёсоор тооцогдоно. Тус тэнхимийн үндэс суурь тавигдсан түүхийг сөхөж үзвээс, анх 1932 онд Цэргийн Ерөнхий Сургуулийн дэргэд "Хуягт танк" гэдэг нэрээр байгуулагдаж, хичээллэж эхэлсэн нэгэн дамжааг тэр үед орос сургагч, орчуулагч багшийн хамтаар удирдаж байсан нь чухамдаа тус тэнхимийн түүхэн эхлэл болсон байдаг.

БНМАУ-ын Хувьсгалт улаан цэргийн Зөвлөлийн 1932 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 27 тоот тушаалд: "...Цэргийн ерөнхий сургуулийн орон тоонд хуягт тэрэг ба танкын курсыг 5 дугаар сарын 26-наас шинээр нээж, бичиг үсэг бүхий бие эрүүл 16 хүнийг

боломжтой, цаг үеийн шаардлагыг хангахуйц болсон тул мөн оны 9 дүгээр сарын 01-ээс хичээл эхлэхээр болжээ. Сургуулийн захирлын тушаалаар ерөнхий цэргийн кафедрын биеийн тамирын нэг



суралцуулахаар оруулахын хамт орчуулагч нэгийг нэмж хангасугай" гэсэн байна.

Сонирхуулахад, энэхүү ангид суралцагчдын зарим нь лам байснаа, 1928-1929 онд "хар хүн" болж, улмаар нам, эвлэлийн гишүүд болсон талаар Цэргийн ерөнхий сургуулийн танкын секцийн даргаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Лүндэвийн Сэрээнэн 1991 оны 10 дугаар сард дурсан ярихдаа, "... танкынхан хоорондоо их эвсэж, дайчин хамт олон байсан юм", "...ууг түүхийг нь бид мэдэхгүй боловч секц анх байгуулагдахад Пашка гэдэг нутгийн орос хүн даргаар ирсэн гэж хүмүүс ярьдаг байсан" гэж дурсан ярьснаас үзвэл Пашка гэдэг орос хүн орчуулагч байсан гэдэг. Тэр үед нь сургагчдын салааны захирагч, Бүрэнгийн Готов, техникийн орлогч Рэнцэнгийн Санжмятов нар байсан талаар тэмдэглэгдэн үлдсэн байдаг. 1938 оныг хүртэлх хугацаанд тодорхой баримт бичиг гэхээр зүйлгүй, бичиж үлдээсэн зүйл ч үгүй байсан хэдий ч 1933 оны 5 дугаар сард ЦЕС-ийн 12 дахь төгсөлтөөр хуягт ангийг 16 хүн төгссөн талаарх баримт хадгалагдан үлджээ.

1925 оны 7 дугаар сард Ардын засгийн газрын хурлын олон гишүүн зөвлөлдөн 28 дугаар тогтоол баталж, Улаанбаатар хотын цэргийн ангиудаас жолооч болон цэргийн алба хаах хүсэлтэй 21 хүнийг сайн дураар элсүүлж, мэргэжлийн түр курс байгуулж, Зөвлөлтийн улаан цэргийн мэргэжилтэн Релисов, Чернов нар монгол нөхдөд мэргэжлийн хичээл зааж, 3 сарын дотор зохих мэргэжил эзэмшүүлж байжээ хэмээн "Одонг ангиуд" гэдэг номд БХЯ-ны архивын дарга агсан хурандаа Наадгай тэмдэглэсэн байдаг. Энэ бүгдээс үзэхэд, манай цэрэгт байсан мэргэжлийн хүн бэлтгэх туршлагадаа тулгуурлаж, Ерөнхий сургуулийн дэргэд "Хуягт анги" нэрээр танкын курс байгуулсан гэдэг.

Монгол улсын төр засгаас тухайн үеийн олон улсын харилцаа, хүйтэн дайны нөхцөл байдлаас улбаалан улс орныг батлан хамгаалах талаар 1970-1980-аад оны үед тодорхой хэдэн арга хэмжээг авсны нэг нь Зэвсэгт Хүчний зэвсэглэлд шинэ төрлийн хуягт танкийн техникийг оруулж, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх асуудал байлаа. Энэ хүрээнд 1978 оны 10 дугаар сард ЦЕДС (хуучин нэрээр)-ийн захирал хошууч генерал Ж.Ёндон, Ерөнхий цэргийн кафедрын танкын тактикийн багш дэд хурандаа Ц.Гончиг, Автын кафедрын багш ахмад А.Долгорсүрэн нарт үүрэг өгч, ЗХУ-ын (хуучин нэрээр) танкийн цэргийн сургуульд дээд боловсролтой офицер, хуягт танкийн ашиглалтын инженер бэлтгэдэг хөтөлбөрийг үндэслэн дотооддоо мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр боловсруулж батлуулахыг даалгасан байдаг.

Тухайн үед тус хөтөлбөр нь дээд боловсролтой офицер бэлтгэх

боломжтой, цаг үеийн шаардлагыг хангахуйц болсон тул мөн оны 9 дүгээр сарын 01-ээс хичээл эхлэхээр болжээ. Сургуулийн захирлын тушаалаар ерөнхий цэргийн кафедрын биеийн тамирын нэг

курсиг шууд хуваарилж шилжүүлсэн нь хөтөлбөрт хамрагдах анхны 25 сонсогч байлаа. 1978 оны 9 дүгээр сард байгуулагдсан тус тэнхимийн анхны даргаар МАА-ийн 036 дугаар ангийн штабын дарга хошууч Г.Цэнд-Аюушийг, Ц.Гончиг, А.Долгорсүрэн, инженер хошууч С.Сэдэд нарыг багшаар, дэслэгч Казыдхань лаборантаар тус тус томилж ажиллуулсан байна. Тэр үед шилжүүлэн хуваарилагдсан сонсогч нар "мэргэжлийг" нь өөрчилсөнд дургүйцэж, хичээлд идэвхгүй байх, цагийн хуваарь зөрчих зэрэг дутагдал гаргадаг болсон учир сургуулийн захирал генерал Ж.Ёндон нэг өдөр



өөрийн албан өрөөнд энэ курсын сонсогчдыг хүлээн авч ВТ янжуураар тамхилж, чин сэтгэлийн ярилцлага хийж, энэ мэргэжил зайлшгүй чухал шаардлагатай байгааг бүгдэд ойлгуулж билээ гэж тус тэнхимийн анхны багш нарын нэг А.Долгорсүрэн агсан хуучилжээ.

1978 онд батлагдсан сургалтын хөтөлбөр нь тухайн үеийн ЗХУ-ын Одесса хотын Цэргийн нэгдсэн дээд сургуульд, хуягт танкын техникийн мэргэжилтэн бэлтгэдэг байсан хөтөлбөрт үндэслэсэн бөгөөд 39 төрлийн хичээлийг 6324 цаг үздэгээс нийт цагийн 22,0 хувь нь нийгмийн ухаан, 48,9 хувь нь цэргийн техник, 14,5 хувь нь ерөнхий эрдэм, 11,1 хувь нь инженерийн ерөнхий онолын хичээл байв. Энэ хөтөлбөрийг 1987 он хүртэл мөрдөж хичээллэсэн юм.

1979-1980 оны хичээлийн жилээс энэ дамжааг өргөтгөн зохион байгуулж, "А", "Б" хоёр дамжаанд шинээр сонсогч элсүүлэн авч, ротын зохион байгуулалтад оруулжээ. Ротын захирагчаар ахмад Л.Буянтогтох, курсын даргаар дэслэгч Л.Мягмар, дэслэгч Д.Содном, дэслэгч С.Ноов нар ажилласан байдаг. Кафедрын орлогч даргаар хошууч Пүрэвдорж, багшаар дэд хурандаа Ж.Таяа, ахмад Д.Мягмар, Шаравжамц, Б.Доржпалам нар томилогджээ. 1980 онд багш Б.Доржпалам хуягт танкын академид суралцахаар явсан ба ахлах дэслэгч С.Ноов, механик-инженер ахмад

Ч.Баттөмөр нар тус кафедрт багшаар томилогдож ирсэн байна. 1980-1981 оны хичээлийн жилд дахин "А", "Б" хоёр курсыг шинээр эхлүүлж, ротын захирагчаар ахмад Нанзаддорж, ротын улс төрийн орлогчоор Батхүү, курсийн даргаар ахлах дэслэгч Нацагдорж, дэслэгч Мөнхсүх, багшаар хошууч Б.Хулжаадай нарыг томилсон ба 1981-1982 оны хичээлийн жилд дахин хоёр курст элсэлт авч дэд хурандаа Ж.Таяа, ахмад Д.Мягмар, Шаравжамц нарыг багшаар, дэслэгч Казыдхань, Нанзаддорж, Содном, Жаргалсайхан, Алтангарьд нарыг салбарын офицероор тус тус томилон ажиллуулжээ.

Сургалтын материаллаг баазыг улам бэхжүүлж, Т-55 танк, БМП-1 явган цэргийн байлдааны машин, БТР-60ПБ дугуйт хуягт тээвэрлэгчийн зангилага, механизм, эд ангийн зүсмэл үзүүлэн, өнгөт зургийн плакат, танкийн цахилгаан тоноглолын ДЭС-155 стэнд зэргээр хичээлийн танхимаа тохижуулж, сургалтад ашиглах болсон байна.

1982 онд танкын курсын анхны төгсөлт болж, 25 хүн төгсөхөд сонсогч Ц.Ядмаа сургуулиа "Онцсайн" дүнтэй төгсөж, БХЯ-ны сайдын дурсгалын бичигтэй бугуйн цагаар шагнуулж байсан нь энэ шинэ мэргэжлээр сургалт сайн явагдаж байсныг гэрчилнэ. 1983 онд хошууч Л.Уртнасан, ахмад Н.Довчинбауу нар Москвад хуягт танкийн цэргийн академийг оператив-тактикийн мэргэжлээр төгсөж ирээд тактик, галын бэлтгэлийн багшаар ажиллах болсон байна. Энэ онд нийт 55 хүн

төгссөнөөс сонсогч Ц.Доржготов, сонсогч Д.Баатархүү нар "Онцсайн" дүнтэй төгсжээ.

Тэнхимийн багшлах боловсон хүчнийг бэхжүүлэх зорилгоор мөн онд инженер хошууч Б.Хулжаадайг багшаар томилжээ. Тэнхим улам өргөжиж сонсогчийн 2 роттой, 8 курстэй болсон ба ахмад Н.Савхиран, М.Мөнхсүх, Л.Мягмар, Батхүү, ахлах дэслэгч Т.Дашнамжил, Энхболд, Батбаяр, дэслэгч Ж.Бямба-Очир, О.Сүхээ нар салбарын офицероор ажиллаж байлаа. Мөн оны дундуур дэслэгч Ц.Ядмаа, Ж.Батнасан нарыг курсын захирагчаар томилсон байна. 1983 оны төгсгөлөөр гадаадын цэргийн дунд, дээд сургууль, академи төгссөн өндөр боловсролтой офицерууд болох дэд хурандаа Сайнжаргал, хошууч Өлзийбаяр нарыг тэнхимд багшаар томилсон байдаг.

Өнгөрөн одсон энэ цаг хагацаатай хамт эргэлт шинэчлэлийг хийж явсан хуягт танкын түүхэн замнал нэр их ээ. Түүнээс гадна танчин хэмээх эрхэм нэр алдрыг хүртсэн олон арван мэргэжилтэн, дээд боловсролтой офицер, ахлагч нар зөвхөн Зэвсэгт хүчний эгнээнд төдийгүй улс эх орны өнцөг булан бүрд төрийн алба хашиж, тусгайлан чиг үүрэг бүхий олон байгууллага, нутгийн захиргааны голлох байгууллагад ажиллаж, мэргэжлийн өндөр боловсрол, уран чадвараа харуулж, нэр төрөө мандуулж явна.